



Чин сэтгэл, хамтын хүчээр бүтээв. Гүний уурхайн Үйлдвэрлэлийн баг.

2024 ЖИЛИЙН ТАЙЛАН



МАНАЙ БИЗНЕС




Оюу толгой нь Өмнөговь аймгийн өргөн уудам нутаг дэвсгэрт орших дэлхийн хэмжээний зэс, алтны томоохон ордын нэг юм. 2011 онд ил уурхайн олборлолт, 2013 онд зэсийн баяжмалын үйлдвэрлэл, 2023 онд гүний уурхайн олборлолтоо эхлүүлж, өдгөө Монголд сүндэрлэсэн аж үйлдвэрийн хамгийн том цогцолбор уурхай болоод байна.

Орчин үеийн дэд бүтэц, уул уурхайн дэвшилтэт технологи бүхий тус уурхай нь ирээдүйд дэлхийн зэсийн үйлдвэрлэлийн томоохон тоглогч болох юм. Энэ нь Монгол Улсад ирээдүйд ч үр өгөөжөө өгөх аюулгүй, орчин үеийн уул уурхайг ажиллуулахаар зорьж буй бидний хүчин чармайлтын илрэл билээ.

Бидний “Хөгжил дэвшлийг хамтдаа бүтээе!” урт хугацааны стратеги нь Монгол Улсын эдийн засгийн тогтвортой өсөлтийг хадгалж, ирээдүйд илүү их үнэ цэн бий болгоход чиглэж буй. ТУЗ-ийн зөвлөмжид түшиглэн боловсруулсан энэхүү стратеги нь тавьсан зорилгодоо хамтдаа хүрэх, ирээдүйд бэлтгэлтэй байх луужин юм.

“Оюу толгой” ХХК-ийн 34 хувийг Монгол Улсын Засгийн газар, 66 хувийг Рио Тинто компани эзэмшдэг бөгөөд Рио Тинто компани хувьцаа эзэмшигчдийн нэрийн өмнөөс уурхайн үйл ажиллагааны менежментийг хариуцан ажилладаг. 2029 он хүртэл олборлолтоо нэмэгдүүлснээр манай уурхай дэлхийд олборлолтоороо дөрөвт орох зэсийн томоохон бизнес болох юм.



2024 ОНЫ ТООН ҮЗҮҮЛЭЛТ

Гэмтэл, бэртлийн давтамжийн үзүүлэлт (AIFR)

0.17

Дотоодод зарцуулсан нийт мөнгөн хөрөнгө

2,078 сая ам.доллар



Нийт зэс, алтны үйлдвэрлэл

215 мян.тонн зэс
206 мян.унц алт

Өмнөговь аймгийн хэмжээнд хийсэн худалдан авалт

299 сая ам.доллар



Ус дахин ашиглалтын хувь

88.4%

Нийт ажиллах хүч (2024 оны жилийн эцсийн байдлаар)

20,545
ОТ ХХК: 4,674



Стратегийн тэргүүлэх чиглэлүүд


Хөгжил дэвшлийг хамтдаа бүтээе!

ШИЛДЭГ АЖИЛ ОЛГОГЧ БАЙНА

- Эрүүл, аюулгүй, хүн бүрийн оролцоо, олон талт байдлыг дэмжсэн ажлын орчин бүрдүүлж, соёлыг төлөвшүүлнэ.
- Үе үеийн төлөөлөл мөр зэрэгцэн урам зоригтой ажиллах боломж бүрдүүлж, чадварлаг ажилтнуудыг эгнээндээ элсүүлж, тогтвортой ажиллах урам зоригоор тэтгэнэ.
- Дэлхийн түвшинд үнэлэгдэхүйц өндөр ур чадвартай мэргэжилтэн бэлтгэнэ.

ЭХ ДЭЛХИЙГЭЭ ЭРХЭМЛЭН ХАМГААЛНА

- Хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах дэлхий нийтийн үйлсийг компани даяараа онцгойлон чухалчилж, биелүүлэх арга замыг эрэлхийлнэ.
- Биологийн төрөл зүйлийн олон янз байдлыг хамгаалж, сайжруулна.
- Компанийн үйл ажиллагаанаас газар, ус, агаарын чанарт учирч болох сөрөг нөлөөллөөс сэргийлж, бууруулна.
- Улс орны хэмжээнд усны аюулгүй байдлыг хангах чиглэлээр хамтарч ажиллана.
- Уурхайн хаалтын дараах нөлөөллийг багасгахад чиглэсэн бизнесийн үйл ажиллагааг явуулна.



ХӨГЖИЛ ДЭВШЛИЙН ТҮНШ БАЙНА

- Хувьцаа эзэмшигч болон оролцогч талуудтай итгэлцэлд суурилсан харилцааг хөгжүүлж төлөвшүүлнэ.
- Харилцан ашигтай зорилгын төлөө оролцогч талуудтайгаа нэгдэнэ.
- Үндэсний хэмжээнд болон орон нутгийн түвшинд эдийн засгийг төрөлжүүлэн хөгжүүлэх үйл явцыг хурдасгах зорилгоор бизнесийн түншүүдтэйгээ хамтарч ажиллана.
- Үйл ажиллагаа явуулж буй орон нутагт тогтвортой хөгжлийг дэмжих чиглэлээр түншилж ажиллана.

ТОГТВОРТОЙ ҮНЭ ЦЭН БҮТЭЭНЭ

- Урт хугацаанд үр ашгаа хүртээх, дэлхийд тэргүүлэх зэсийн үйлдвэрлэлийг цогцлооно.
- Стратегиа оновчтой төлөвлөж, хүдрийн биетийн судалгаанд хөрөнгө оруулах замаар үр ашгийг боломжит дээд түвшинд хүргэж нэмэгдүүлнэ.
- Нэгдмэл, уян хатан, шинийг санаачилдаг, шинэ техник, технологи ашигладаг, тасралтгүй суралцдаг тэргүүний компани байна.
- Ханган нийлүүлэлтийн сүлжээ, түүний дотор цахилгаан эрчим хүчний чадамж, тогтвортой байдлыг сайжруулж, дээд зэрэглэлийн бүтээгдэхүүнийг илүү олон харилцагчдад нийлүүлнэ.



Гүйцэтгэх захирлын зурвас



2024 он “Оюу толгой” компанийн хувьд бэрхшээлийг даван туулж, ахиц дэвшилд тэмүүлж, бодит үр дүн авчирсан онцгой жил байлаа. Бид үйл ажиллагаагаа тогтворжуулж, шинэ санаачилгууд хэрэгжүүлэн, ажилтнууд, түншүүд болон Монгол Улсын тогтвортой хөгжилд оруулах хувь нэмрээ улам ахиулж ажиллалаа. Аюулгүй ажиллагааг чухалчилж, ажилтнуудынхаа сайн сайхан байдалд гол анхаарлаа хандуулсаар ирсэн нь үр дүнгээ өгч, Гүний уурхайн төсөл, Үйл ажиллагааны хэлтсийн аюулгүй ажиллагааг онцлон Рио Тинтогийн “Аюулгүй ажиллагааны шилдэг гүйцэтгэлтэй уурхай” шагналыг хүртлээ. Оролцоо, олон талт байдлыг хангах зорилтод мэдэгдэхүйц өөрчлөлт гарч, Оюу толгойн ажилтнуудын 23,3 хувийг, Гүйцэтгэх удирдлагын багийн 50 хувийг эмэгтэйчүүд бүрдүүлдэг болов.

Түншлэл хамтын амжилтыг бүтээдэг. Бид 1,000 гаруй үндэсний ханган нийлүүлэгчтэй болж, тэдэнтэйгээ хамтран ажилласан нь орон нутгийн бизнесийг нэмэгдүүлж, “Монголд үйлдвэрлэв” хөтөлбөрийг дахин сэргээхэд хувь нэмрээ орууллаа. Оюу толгойн “Ханбогдын хөгжлийн хурдасгуур сан” нь Ханбогд сумыг орчин үеийн, хөгжингүй хот болгох урт хугацааны зорилтоо хэрэгжүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэж, шинээр зам тавих, Галба цэцэрлэгт хүрээлэнгийн шинэчлэл зэрэг дэд бүтцийн томоохон төслүүдийг амжилттай хэрэгжүүллээ. “Ажиллах хүчний орон байрны нөхцөлийг сайжруулах, Ханбогдыг хот болгон хөгжүүлэх” цогц хөтөлбөр нь “Өдөр бүр хүндэтгэе” санаачилгын хүрээнд хөндөж тавьсан ажилтнуудын асуудлуудыг шийдвэрлэхийн зэрэгцээ ажлын болоод амьдрах орчин нөхцөлийг сайжруулахад чиглэж байна.

Тогтвортой хөгжлийн хүчин чармайлт дараагийн түвшинд хүрч, 1.3 сая мод биетээр суулган, нөхөн сэргээлт зэрэг бусад томоохон ажлуудаа дүйцүүлэн тооцвол нийт 20 сая мод тарьсан амжилт бүхий жил байлаа. Шинийг санаачлан турших нь бидний үйл ажиллагааны гол цөм билээ. Ил уурхайн хүнд даацын өөрөө буулгагч техникт батарей солих технологийг туршин нэвтрүүлсэн нь салбартаа түүчээлсэн,тогтвортой хөгжилд тэмүүлсэн санаачилга болов.

2024 он үйл ажиллагааны хувьд сорилтоор дүүрэн жил байлаа. Төлөвлөгдөөгүй зогсолтууд, техникийн саатлаас үүдэлтэй үйлдвэрлэлийн төлөвлөгөө, санхүүгийн гүйцэтгэл зэрэгт хүндрэл тулгарсан ч хамт олны маань гайхалтай тэсвэр хатуужил, хариуцлагатай чанар нь төлөвлөгөөт засваруудаа амжилттай хэрэгжүүлэхэд түлхэц болж, цаг хугацаанд нь гүйцэтгэж чадсан. Үүний дотор, Оюу толгойн түүхэн дэх хамгийн томд тооцогдох засвар буюу Баяжуулах үйлдвэрийн тээрмийн засвар үйлчилгээг аюул осолгүй, товлосон хугацаанд нь гүйцэтгэсэн явдал зүй ёсоор орно.

Мөн гүний уурхайн 3,4-р босоо ам, гүнээс гадарга руу хүдэр зөөвөрлөх туузан дамжуулагчийн системийг амжилттай ашиглалтад оруулж, Панел 1, 2-ын бүтээн байгуулалтыг эхлүүлсэн нь манай компанийн цаашдын үйл ажиллагааны тогтвортой байдлыг хангахад чухал алхам болов. “Оюу толгой” ХХК Монгол улсын “ТОП 100 Аж ахуйн нэгж”-ийн жагсаалтыг хоёр дахь жилдээ тэргүүлсэн нь улс орны нийгэм, эдийн засгийн хөгжилд оруулж буй бодитой хувь нэмрийг илтгэн харууллаа.

2025 он Оюу толгойн хувьд өөрчлөлт шинэчлэлтийн жил байх болно. Баяжуулах үйлдвэрийн өргөтгөл, Панел 2-ын улаар таслах үйл ажиллагааг эхлүүлэх, Анхдагч бутлуур 2-г ашиглалтад оруулах зэрэг томоохон ажлуудаа урагшлуулж, хувьцаа эзэмшигч, түнш, оролцогч талуудынхаа хүлээлтийг биелүүлэхийн тулд үйлдвэрлэлийн хүчин чадлаа нэмэгдүүлэх чухал жил байх болно.

ДЭЙРДРЭ ЛИНГЕНФЭЛДЕР
Гүйцэтгэх Захирал

Удирдлагын баг

ДЭЙРДРЭ ЛИНГЕНФЭЛДЕР Гүйцэтгэх Захирал	ЭНДРЬЮ ЛАЯ Уурхайн үйл ажиллагаа эрхэлсэн Захирал (2024 оны 4 сараас)	БЭГЭЖАВЫН ДУЛАМСҮРЭН Санхүү эрхэлсэн Захирал
ДАШНЯМЫН АМАРБАЯСГАЛАН Хууль, эрх зүйн асуудал хариуцсан Захирал	ПҮРЭВСҮРЭНГИЙН БАЙГАЛМАА Бизнесийн шинэчлэл хариуцсан Ерөнхий менежер (2024 оны 8 сараас)	ДЭМИЭН РОЖЕРС Гүний уурхайн төслийн Удирдагч
МЕНАНД КАРСАН Зэсийн баяжмалын борлуулалт хариуцсан Ерөнхий менежер	МЕЛИССА ШАНЕНГАНГЕ Боловсон хүчин, бүтэц зохион байгуулалт хариуцсан Ерөнхий менежер	БОЛДЫН ӨСӨХБАЯР Гүйцэтгэх захирлын Тэргүүн зөвлөх (2024 оны 9 сараас)
ФИЛИП АБРАХАМ Эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа, байгаль орчин, орон нутаг хариуцсан Ерөнхий менежер	ЭНХСАЙХАНЫ ХОНГОРЗУЛ Гадаад харилцаа, олон нийттэй харилцах газрын Ерөнхий менежер (2024 оны 9 сараас)	ХИКМЕТ ГАИБОВ Худалдан авалтын газрын Ерөнхий менежер (2024 оны 1 сараас)
ЭНХСАЙХАНЫ АНХБАЯР Ил уурхай, хөрөнгийн удирдлага хариуцсан Ерөнхий менежер (2024 оны 8 сараас)	МАЛХУУЗЫН ГАНБОЛД Баяжуулах үйлдвэр, мэдээллийн технологи, логистик хариуцсан Ерөнхий менежер	ТОГТОХБАЯРЫН ОТГОНБАЯР Техникийн үйлчилгээ болон өсөлт хариуцсан Ерөнхий менежер
СТЕФАН ХЕРСЕЛМЕН Гүний уурхайн үйл ажиллагаа хариуцсан Ерөнхий менежер	ГОНЧИГЖАНЦАНГИЙН СУГАР Орон нутаг хариуцсан Ерөнхий менежер	ТОММИ КАНКУНЕН Уурхайн дэд бүтэц, үйлчилгээ хариуцсан Ерөнхий менежер



ХАМТ ОЛОН

ШИЛДЭГ АЖИЛ ОЛГОГЧ БАЙНА

Эрүүл, аюулгүй орчин, оролцоо ба олон талт байдлыг дэмжсэн ажлын байр, соёлыг бүрдүүлнэ.

Ажлын өдрийн эхлэл: Гүний уурхайн Үйлдвэрлэлийн босоо ам 2-оос бидний ээлж эхэлдэг.



Монгол ажилчид

97.5%

0.3%  vs 2023

Гадаад ажилчид

2.5%

4,674

“Оюу толгой” ХХК-ийн
нийт ажиллах хүч

Өмнөговийн
ажилчид

24.7%

1.7%  vs 2023

Бид эрүүл, аюулгүй ажлын байрыг бий болгож, хүн бүрийн оролцоо, олон талт байдлыг хангахын төлөө тууштай ажилладаг. Манай ажилчдын 97.5 хувь нь Монголчууд бөгөөд тэд дэлхийн хамгийн том, дэвшилтэт технологи бүхий уурхайн нэгийг бүтээх их үйлсийн тэргүүн эгнээнд зүтгэж байна.

Аюулгүй ажиллагааг нэн тэргүүнд тавьж, ажлын байраа илүү аюулгүй болгох ажилтнуудынхаа санаачилгыг ямагт дэмжсээр ирлээ. Сүүлийн арван жилд Гэмтэл, бэртлийн давтамжийн үзүүлэлт (AIFR) тогтвортой буурч, 2024 онд 0.17-д хүрсэн нь биднийг Рио Тинтогийн хамгийн аюулгүй уурхайн нэг болгоод байна. 2024 оны наймдугаар сард Оюу толгойн Гүний уурхайн төслийн баг Рио Тинтогийн “Аюулгүй ажиллагааны шилдэг гүйцэтгэлтэй уурхай” шагналыг анх удаагаа хүртсэнээрээ онцлог байлаа. Энэ нь Оюу толгой үйл ажиллагаандаа хэрэгжүүлж буй аюулгүй ажиллагааны шилдэг гүйцэтгэл, манлайллыг онцолсон шагнал байлаа.

Гэмтэл бэртлийн давтамжийн үзүүлэлт (AIFR)

(200,000 хүн/цагт ногдох)



Хэдийгээр ахиц, дэвшил гарч буй боловч сонор сэрэмжтэй байж, илүү аюулгүй ажлын байрыг бий болгохоор зорин ажиллаж байна.

Эрүүл, аюулгүй, олон талт, оролцоог хангасан хамт олон


Оюу толгой бол зөвхөн ажлын талбар биш юм. Бид арьс өнгө, нас, хүйс, албан тушаал, гарал угсаа, тусгай хэрэгцээнээс үл хамааран үнэ цэнтэй, хүндлэгдсэн ажлын орчинд ажиллах нөхцөлийг бүрдүүлэхийг үргэлж эрмэлздэг. Олон талт, оролцоо нь манай байгууллагын соёлын чухал хэсэг бөгөөд бид хүн бүрийг тэгш боломжоор хангахын төлөө бодитой алхмуудыг тасралтгүй хийсээр байна.



ЭМЭГТЭЙ АЖИЛЧИД **23.3%** ЗОРИЛТ 25%

2024 онд олон талт байдлыг дэмжих чиглэлээр ахиц гарган, эмэгтэй ажилчид нийт ажилчдын 23.3 хувийг эзэлж дэлхийн уул уурхайн салбарын дундаж болох 15 хувь (Дэлхийн Банкны тайлан, 2024 он)-аас илүү үзүүлэлттэй байна. Түүнчлэн, удирдах албан тушаал дахь эмэгтэйчүүд 35.7 хувьд хүрсэн нь бидний урт хугацаандаа эмэгтэй ажиллах хүчийг 50 хувьд хүргэх зорилгодоо ахиц гаргаж буйг илтгэж байна.

Хөгжлийн бэрхшээлтэй ажилтны тоо



Хөгжлийн бэрхшээлтэй ажилчдын тоо 48-д хүрч, нийт ажилчдын 1 хувьд хүргэх зорилтоо давуулан биелүүлснээр олон талт байдал, хүртээмжийг сайжруулахад чухал үүрэг ахиц гарлаа.

Энэхүү ахицыг улам бататгахын тулд бид хөндлөнгийн мэргэжлийн байгууллагаар Ажлын байрны хүртээмжийн үнэлгээг хийлгэж, хүртээмжийг нэмэгдүүлэхэд цаашид илүү сайжруулах, анхаарах шаардлагатай хэсгүүдийг үнэлсэн юм.

Уг үнэлгээний үр дүнгээс гарсан зөвлөмжийг 2025 оноос хэрэгжүүлж эхлэх бөгөөд энэ нь хүн бүрд хүртээмжтэй, илүү нээлттэй ажлын орчныг бүрдүүлэхэд чиглэсэн чухал алхам болох юм.

Үе үеийн төлөөллүүд мөр зэрэгцэн урам зоригтой ажиллах ажлын байр


Тасралтгүй суралцах, хөгжих боломжийг бүрдүүлэх зорилгоор бид Оюу толгой ХХК-ийн ажилчид болон гэрээт ажилчдаа шаардлагатай ур чадварт сурган, хөгжүүлэхийг үргэлж эрхэмлэдэг.

2024 онд давхардсан тоогоор нийт 121,596 ажилчдыг сургалтад хамруулсан бөгөөд нэг ажилтан дунджаар зургаан сургалтад хамрагдсан юм. Эдгээр сургалтууд нь гүний уурхайн ажиллагаа, өндөр эрсдэлтэй бүсийн аюулгүй ажиллагаа, сэрээт өргөгч, хүнд машин механизмын оператор, алсаас удирдах операторын сургалт зэрэг энгийн болон мэргэжлийн үнэмлэх олгох сургалтууд юм.

Бид тасралтгүй суралцах соёлыг төлөвшүүлэх замаар үе үеийн ажилчид мөр зэрэгцэн өөрсдийн хувь нэмрээрээ бахархдаг, ирээдүйд бэлэн, чадварлаг ажиллах хүчийг бүрдүүлэхийг зорьж байна.



Монгол ажилчдын эзлэх хувь



Оюу толгой компани нь орон нутгийн ажиллах хүчнийг хөгжүүлж, чадавхжуулах ажлыг нэн тэргүүнд тавьж, үйл ажиллагааны бүхий л талбарт орон нутгийн ажилчдын төлөөллийг бий болгохыг зорьдог. 2024 онд манай нийт ажилчдын 97.5 хувь нь Монгол ажилчид байсан бол үүнээс 24.7 хувь нь Өмнөговь аймгийн иргэд байна.

Энэ нь уул уурхайн чадварлаг мэргэжилтнүүдийг бэлтгэн, тэднийг дэлхийн түвшинд өрсөлдөх ур чадвар, туршлагаар хангах зорилготой хичээл зүтгэлийн үр дүн юм.

Шударга, нээлттэй, хамтын ажиллагааг эрхэмлэсэн ажлын орчныг бүрдүүлэхийн төлөө бид “Оюу толгой” ХХК-ийн Уул уурхайн ажилтны үйлдвэрчний эвлэлийн хороо болон “Оюу толгой” ХХК-ийн Орон нутгийн ажилчдын үйлдвэрчний эвлэлийн хороотой хамтран

Хамтын гэрээгээ дахин байгууллаа. Харилцан ойлголцол, хүндлэлд суурилсан энэхүү гэрээ нь ажилчдын сайн сайхны төлөөх бидний амлалтыг бататгаж, шилдэг мэргэжилтнүүдийг татах, цаашид тогтвортой ажиллуулахад чиглэсэн юм.





ХАМТЫН АЖИЛЛАГАА

ХӨГЖИЛ ДЭВШЛИЙН ТҮНШ БАЙНА

Хувьцаа эзэмшигч болон оролцогч талуудтай итгэлцэлд суурилсан харилцааг хөгжүүлж төлөвшүүлнэ.

“Оюу толгой” ХХК нь Монгол Улсын “ТОП 100 аж ахуйн нэгж”-ийн жагсаалтыг хоёр дахь жилдээ тэргүүллээ. Мөн манай 30 ханган нийлүүлэгч “Топ 100”-д багтлаа.

Үр дүнтэй хамтын ажиллагаа нь Оюу толгойн амжилтын үндэс суурь юм. Үйл ажиллагаагаа амжилттай явуулахад Монгол Улсын Засгийн газар, орон нутаг, ханган нийлүүлэгчид, худалдан авагчид болоод түншүүдтэйгээ нягт хамтран ажиллах явдал чухал юм.

Түншлэлээр дамжуулан бид хамтын үнэ цэнийг бүтээхийн зэрэгцээ орон нутаг төдийгүй Монгол Улсдаа үр шимийг нь авчирч буй хэрэг юм.

ХАНГАН НИЙҮҮЛЭГЧДИЙН ТОО (2024 оны эцсийн байдлаар)

1,044

8% vs 2023

ӨМНӨГОВЬ АЙМАГТ ХЭРЭГЖҮҮЛСЭН ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

18 сая
ам.доллар

119% vs 2023

ДОТООДЫН ХУДАЛДАН АВАЛТ

1,474 сая
ам.доллар

25% vs 2023

ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ХУДАЛДАН АВАЛТ

299 сая
ам.доллар

10% vs 2023

Үндэсний худалдан авалтын сүлжээг өргөжүүлэх нь манай байгууллагын хамтын ажиллагааны нэн чухал хэсэг юм. Өнөөг хүртэл нийт худалдан авалтын 90 хувийг дотоодын худалдан авалт эзэлж байгаа нь үндэсний бизнесүүдээ дэмжих бодлогоо тууштай хэрэгжүүлж буйн тод илрэл юм.



Үндэсний ханган нийлүүлэлтийн сүлжээг бэхжүүлнэ



2024 онд Оюу толгой компани ханган нийлүүлэгчдээ чадавхижуулах, тэдний ажиллах хүчийг нь сургаж хөгжүүлэх, орон нутагт хөрөнгө оруулах зэрэгт голанхаарлаа хандуулж ажилласан нь урт хугацаандаа үнэ цэнийг бүтээх, орон нутгийг хөгжүүлэх амлалтаа биелүүлж буйн илрэл юм.

Бид дотоодын ханган нийлүүлэгчдийнхээ сүлжээг бэхжүүлэхэд анхаарч, 1,044 ханган нийлүүлэгчтэй хамтран ажилласны 752 нь дотоодын аж ахуйн нэгж байлаа.

2024 оны эцсийн байдлаар Өмнөговийн 413 ханган нийлүүлэгч 299 сая ам.долларын бараа, үйлчилгээ нийлүүлсэн нь тус аймгаас хийсэн худалдан авалтыг 1.72 тэрбум ам.долларт хүргээд байна. Энэхүү хөрөнгө оруулалтын үржүүлэгчийн нөлөөгөөр* орон нутгийн бизнесүүдийг дэмжээд зогсохгүй ажлын байрууд шинээр бий болж байна.

“Монголд үйлдвэрлэв” санаачилгын хүрээнд ханган нийлүүлэгчид маань шинэ технологи нэвтрүүлснээр баяжуулах үйлдвэрт хэрэглэж буй шохойг 100 хувь дотооддоо үйлдвэрлэдэг болсон.

“Оюу толгой” ХХК “ТОП-100” аж ахуйн нэгжийн жагсаалтыг хоёр дахь жилдээ тэргүүлээ. Хамгийн чухал нь манай 30 ханган нийлүүлэгч компани мөн энэхүү нэр хүндтэй жагсаалтад багтсан нь үндэсний ханган нийлүүлэлтийн найдвартай сүлжээг хөгжүүлэх бидний хүчин чармайлтын илэрхийлэл болж байна.

* Тооцоолсон үржүүлэгчийн нөлөө 1.4, МУИС-ийн 2021 онд хийсэн Ковид-19 цар тахлын үед Оюу толгойн Монгол Улсын нийгэм эдийн засагт үзүүлсэн нөлөө судалгаа



Залуусын хөгжлийн дэмжлэг

Залуусын боловсрол, мэргэжлийн ур чадварын хөгжил, тэдний сайн сайхан байдалд нь анхаарч, ирээдүй хойч үедээ хөрөнгө оруулах нь Оюу толгойн нийгэмд хандаж хэрэгжүүлдэг гол хөтөлбөр юм.

2024 онд 150 залууст тэтгэлэг олгосон бөгөөд Залуусын хөгжлийн хөтөлбөрийн хүрээгээ тэлж, Дорноговь аймагт хэрэгжүүлж эхлээд байна. 2010 оноос хойш нийт 1,130 оюутан тэтгэлэг хүртэж, 1,660 хүн Залуусын хөгжлийн хөтөлбөрт хамрагдаад байна. Эдгээр боловсролын хөтөлбөрүүдэд 152 сая гаруй ам.долларын хөрөнгө оруулалт хийгээд байна.

Соёлын өв хамгаалахад хамтран ажиллана

Оюу толгой, Рио Тинто Монгол, ЮНЕСКО хамтран “Соёлын болон гео өвд түшиглэн тогтвортой аялал жуулчлалыг дэмжих” төслийг 2024 онд хэрэгжүүлж эхлэв. Гурван жил хэрэгжих тус төслийн хүрээнд Шар Цав, Ханбогд орчмын өвүүдийг хамгаалж, орон нутагт тогтвортой аялал жуулчлал бий болгоход чиглэж буй юм.

Хүүхэд залуусын эрүүл мэндийг хамгаалахад чиглэсэн Гэрэлт төслөө тав дах жилдээ хэрэгжүүлж байна. Энэхүү төсөл өсвөр үеийнхэнд нөхөн үржихүй, сэтгэцийн эрүүл мэндийн ойлголт, мэдлэг олгоод зогсохгүй шаардлагатай нөөц боломжуудыг олгодгоороо онцлог юм.

2024 онд Баянзүрх дүүргийн дөрвөн ЕБС-т тус төсөл хэрэгжиж, сэтгэл зүйн зөвлөгөө өгөх өрөө шинээр бий болгож, эрүүл мэндийн клуб ажиллуулан эрүүл мэндийн сургалтууд явууллаа. Гэрэлт төслийн үр шимийг Сонгинохайрхан, Баянзүрх дүүрэгт амьдарч буй 33,000 сурагч, багш ажилтан, эцэг эх асран хамгаалагчид хамгаалагчдын дунд дэлгэрүүлжээ.



Зудын эсрэг хамтдаа

Монгол Улсын хүн амын 30 орчим хувь нь амьжиргааны эх үүсвэрээ уламжлалт мал ахуйгаас хангадаг. 2023 оны 11-р сараас 5-р сарын хооронд сүүлийн 10 жилд тохиогоогүй зуд* нүүрлэж, улс даяар малчид зудад нэрвэгдэн, 8 сая толгой мал хорогдсон.

“Оюу толгой” компани орон нутгийн иргэддээ дэм болох, гамшгийг сөрөн тэсвэрлэх байдлыг нэмэгдүүлэх үүднээс тус хүндрэлийг даван туулахад 298 сая ам.долларын дэмжлэг үзүүлсэн.



*Агаарын хэм -30С болон түүнээс доош бууж, хүчтэй цасан шуурга, хавсаргаас үүдэлтэй бий болдог байгалийн үзэгдэл

ОРОН НУТГИЙН
ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН
ТӨСӨЛ, ХӨТӨЛБӨРҮҮД



Эрүүл мэнд	6%
Боловсрол	11%
Байгаль орчин	1%
Орон нутгийг бизнес эрхлэлтийг дэмжих	4%
Түүх, соёлын өв	2%
Орон нутгийн дэд бүтэц	70%
Спорт, алжаал тайлах	6%



“Галба” цэцэрлэгт
хүрээлэнгийн шинэчлэл

Бүс нутгийн хөгжлийн төлөөх түншлэл

“Оюу толгой” компани нь 2024 онд орон нутгийн дэд бүтэц, иргэдийн эрүүл мэнд, сайн сайхан байдал, боловсролд чиглэсэн 100 гаруй тогтвортой, урт хугацаанд хэрэгжих нийгмийн хөрөнгө оруулалтын төсөл хөтөлбөрт нийт 18 сая ам.долларын хөрөнгө оруулсан байна. Энэ онд бидний хамтран ажилладаг түншлэгч сумдын 100 жилийн ойн баяр тохиосон онцгой жил байлаа. Бид зуун зуун дамнасан уламжлал, соёлын өвийг хүндэтгэн, бахархалтайгаар хамтран тэмдэглэлээ.

Орон нутгийн хамтын ажиллагааны томоохон хэсэг нь “Говийн оюу хөгжлийг

дэмжих сан”-аар дамжин хэрэгжиж байна. 2024 онд Оюу толгой энэ сангаар дамжуулан Өмнөговь аймгийн нийгэм, дэд бүтцийн хөгжлийн төслүүдэд нийт 6.4 сая ам.долларын хөрөнгө оруулалт хийжээ. Томоохон төслүүдээс дурдвал:

Цэцэрлэгийн шинэ барилга Даланзадгад хотод ашиглалтад оруулснаар “Оюу толгой” компанийн хөрөнгө оруулалтаар бий болсон зургаадах цэцэрлэг Өмнөговь аймагт үүд хаалгаа нээлээ. Тус цэцэрлэг нь 200 хүүхдийн хүчин чадалтай юм.



Хаягдал дахин боловсруулах үйлдвэр нь Даланзадгад хотын үйлдвэрийн бүсэд баригдаж буй бөгөөд одоогоор 90 хувийн гүйцэтгэлтэй, дуусах шатандаа орж байна. Тус үйлдвэр нь авто зам, зогсоол, явган хүний зам, ногоон байгууламж зэргийг цогцоор нь шийдсэн. Тус төсөл нь ажлын байр бий болгох, байгаль орчны бохирдлыг бууруулах, эрүүл, аюулгүй амьдрах орчныг бүрдүүлэх зорилготой бөгөөд хог хаягдлыг ангилан дахин боловсруулж, эдийн засгийн эргэлтэд оруулах ач холбогдолтой юм.

Цэвэр, бохир усны шинэ шугамыг Ханбогд сумын гэр хороололд сүүлийн хоёр жилийн хугацаанд нийт 20.1 км (цэвэр усны) болон 17.6 км (бохир усны) тус тус шинээр суурилуулжээ. Энэхүү төсөл нь 1,000 гаруй өрх, 60 гаруй байгууллагын амьдрах болон ажиллах орчныг сайжруулж, сумын иргэдэд илүү аюулгүй, эрүүл амьдрах нөхцөл бүрдүүлэхэд чухал ач холбогдолтой юм.



“Ханбогдын хөгжлийн мастер төлөвлөгөө” нь тус сумыг оршин суугчдын хэрэгцээг хангахуйц хот болгон хөгжүүлэх урт хугацааны стратегийн чухал төлөвлөгөө юм. Энэхүү төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор Оюу толгойн Төлөөлөн удирдах зөвлөл (ТУЗ) 2022 онд “Ханбогдын хөгжлийн хурдасгуур сан”-г байгуулж, таван жилийн хугацаанд 50 сая ам.долларын хөрөнгө оруулах шийдвэр гаргасан. Өнөөдрийн байдлаар тус сангаас Ханбогд сумын хөгжилд чиглэсэн төслүүдэд 16 сая ам.долларын хөрөнгө оруулалт хийгээд байна. Үүнд:

“Галба” цэцэрлэгт хүрээлэнгийн шинэчлэн тохижуулах төсөл: Нийт 5 га талбайд усан оргилуур, ногоон байгууламж, авто машины зогсоол, ариун цэврийн байгууламж, орчин үеийн гэрэлтүүлэг бүхий иж бүрэн тохижилт хийв.

Зам барилгын ажил: Ханбогд сумын төвд явган хүний болон дугуйн зам, гадаргын ус зайлуулах шугам бүхий 8 км иж бүрэн авто замыг ашиглалтад оруулсан.

Орчин үеийн спорт цогцолбор: Орон нутгийн иргэдийн эрүүл мэнд, идэвхтэй амьдралын хэв маягийг дэмжих зорилготой, 500-н хүний хүчин чадал бүхий байгууламжийн шав тавив.

Ханбогдын Гурван талт зөвлөлийн хамтын ажиллагаа

Гурван талт зөвлөл (ГТЗ) нь Ханбогд сумын удирдлага, нутгийн малчид, “Оюу толгой” компанийн төлөөллийг тэгш хангасан 2015 онд байгуулагдсан зөвлөл юм. Тус зөвлөл нь 2017 оноос малчдын санал гомдлыг үр дүнтэй шийдвэрлэх зорилгоор “Малчдын гомдол барагдуулах гэрээ”-ний хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

2024 онд тус гэрээний хэрэгжилтийг хангах чиглэлээр ахиц гарган малчин өрхүүдийг дэмжих ажлуудыг эрчимжүүллээ. Үүнд оюутны тэтгэлэгт хөтөлбөр, тэжээлийн ургамал туршилтын тариалалт, бэлчээрийн ус хангамжийг сайжруулах зэрэг ажлууд багтсан.

Энэхүү ажлын хүрээнд дөрвөн шинэ гүний худаг барьж, 29 малчдын гар худгийг сэргээн засварлан ашиглалтад орууллаа. Мөн найман малчны худагт нарны зайн систем суурилуулж, ус хангамжийн хүртээмжийг тогтвортойгоор нэмэгдүүлэхэд чиглэн ажиллаа.



ХӨРСТ ДЭЛХИЙ

ЭХ ДЭЛХИЙГЭЭ ЭРХЭМЛЭН ХАМГААЛНА

Газар, ус, агаарын чанарт учирч болох сөрөг нөлөөллөөс сэргийлж, бууруулна.

Сая мод тарих ажил нэг үрээс эхэлнэ.
Сэлэнгэ аймаг дахь нөхөн сэргээлтийн талбай

Байгаль орчноо хамгаалахад чиглэсэн бидний үйл ажиллагаа нь зэсийг хариуцлагатайгаар олборлохын хажуугаар хүрээлэн буй орчны үр нөлөөг багасгахад чиглэдэг. Бид байгууллагын алсын харааныхаа хүрээнд 2050 он гэхэд Оюу толгойн үйл ажиллагаатай холбоотой ялгарч байгаа хүлэмжийн хийг тэглэх зорилт тавин ажиллаж байна. Энэхүү зорилгын хүрээнд шинээр хэрэгжүүлж буй санаачлагууд нь биднийг хүлэмжийн хийн ялгаралаа 25 хувиар бууруулж, жилд 0.79 сая тонн болгоход чухал үүрэг гүйцэтгэсэн. Энэ нь тогтвортой ирээдүйн төлөө бидний хийж буй чухал алхам юм.

Чандмань эрдэнэ болсон усаа хэмнэхийн тулд бид гүний усны хэрэглээгээ багасгаж, ус дахин ашиглалтыг дээд хэмжээнд байлгахыг зорьж байна. “Скарн ассоциаци” байгууллагын судалгаагаар Оюу толгой дэлхий дээрх усыг хамгийн хэмнэлттэй ашигладаг уурхайнуудын нэгт багтсан бөгөөд хэрэглэсэн усныхаа 88.4 хувийг дахин ашиглаж байна.

Бид эрдсийн бус хаягдлын дахин боловсруулалтаа 75 хувиас ахиулах санаачлагуудыг авч хэрэгжүүлж байна.

2024 онд

1.3 сая
мод тарив.

6x ⬆ vs 2023

НИЙТ НӨХӨН СЭРГЭЭСЭН
ТАЛБАЙ

215 га

Шарынгол болон Хонгор сум,
Дархан-Уул аймаг

УС ДАХИН АШИГЛАЛТЫН
ХУВЬ

88.4%
(зорилт 80%)

2.7% ⬆ vs 2023

ДАХИН БОЛОВСРУЛСАН
ХОГ ХАЯГДАЛ

75%

21% ⬆ vs 2023

*Хараат бус тогтвортой хөгжлийн судалгааны байгууллага

ҮНДЭСНИЙ ХЭМЖЭЭНИЙ САНААЧИЛГАД НЭГДЭН АЖИЛЛАЖ БАЙНА

Бид тогтвортой хөгжлийн алсын харааныхаа хүрээнд Монгол Улсыг ойжуулах, ойн салбарыг хөгжүүлэх зорилгыг тавин ажиллаж байна. “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд 100 сая мод тарих бидний амлалт нь байгаль орчныг хамгаалах үйлсэд чухал хувь нэмэр оруулж, урт хугацааны эерэг нөлөөллийг бий болгоход оршиж байгаа юм. Энэхүү санаачилга нь бүс нутгийн экосистемийг бэхжүүлээд зогсохгүй дэлхийн уур амьсгалын тогтвортой байдлыг хангахад дэмжлэг үзүүлэх чухал ач холбогдолтой юм.

100 САЯ МОД ХӨТӨЛБӨР

Бид 1.3 сая мод амжилттай тарьлаа.

Дрон ашиглан үр тарих технологийг Монгол Улсад анх удаа амжилттай хэрэгжүүлж эхлэв.

2024 онд Өмнөговь, Сэлэнгэ, Төв, Дархан-Уул аймгуудад хэрэгжүүлсэн ойжуулалтын үйл ажиллагаагаар 8.4 сая модтой дүйцэхүйц нөхөн сэргээлт хийгдлээ.

Цогт-Овоо сум дахь мод үржүүлгийн төвийг Сум дундын ойн нэгжид, Харин Ханбогд сум дахь мод үржүүлгийн төвийг орон нутгийн Засаг дарга болон хариуцах байгууллагад хүлээлгэн өгч, урт хугацааны ойжуулалт, экосистемийн нөхөн сэргээлтийг дэмжлээ.

2024 онд бид өмнөх онтой харьцуулахад 6 дахин их мод тарьсан байна.

Үйл ажиллагаанаас ялгарч буй хүлэмжийн хийг бууруулах



- Хүлэмжийн хийн ялгаралыг бууруулахад чиглэсэн хүчин чармайлтаа улам эрчимжүүлж, 2024 онд дараах шинэ санаачлагуудыг хэрэгжүүллээ:
- ▶ 90 тонн даац бүхий зай хураагуураар ажилладаг цахилгаан ачааны авто машиныг туршилтаар нэвтрүүлэв.
 - ▶ Гүний уурхайд 14 ширхэг зай хураагуураар ажилладаг цахилгаан тээврийн хэрэгсэлүүдийг хэрэглээнд нэвтрүүлсэн бөгөөд 2025 онд нэмэлт цахилгаан тээврийн хэрэгсэлүүдийг нэвтрүүлэхээр төлөвлөж байна.
 - ▶ Уурхайн цогцолборт сэргээгдэх эрчим хүчний шинэ эх үүсвэрүүдийг туршиж байна.
 - ▶ Монгол Улсад хүлэмжийн хийн зах зээлийг хөгжүүлэх суурийг тавихаар ажиллаж байна.

Тогтвортой хөгжлийг түүчээлнэ




Усны үр ашигтай хэрэглээгээр дэлхийд тэргүүлэгч томоохон зэсийн уурхайнуудын нэг болохын хувьд тогтвортой усны менежментийн шинэ стандартыг тогтоосон хэвээр байна.

2024 усны үр ашигтай хэрэглээгээр дэлхийд тэргүүлэгчдийн эгнээнд багтсан үзүүлэлтээ хадгалж, дэлхийн 157 зэсийн уурхайн дундаж үзүүлэлттэй харьцуулахад өндөр үнэлгээ авсан юм. Скарн ассоциацийн 2024 судалгаагаар салбарын дундаж усны хэрэглээ 1 тонн хүдэр боловсруулахад 1,200 литр байгаа бол Оюу

толгой 342 литр ус ашиглаж байна. Энэ нь дэлхийн дунджаас бараг гурав дахин бага гэсэн үг юм.

2024 оны эцсийн байдлаар бид 80 хувийн ус дахин ашиглах зорилтоо давуулан биелүүлж, **88.4** хувьд хүргэлээ.



Оюу толгой уурхайн Хаягдал хадгалах байгууламжаас үүсэх нэвчилтийн эрсдэлийг тогтмол хянадаг. Засаж сайжруулах ажлын төлөвлөгөөний хүрээнд орон нутгийн 871 малчин, орон нутгийн удирдлага, иргэний нийгмийн төлөөллүүдтэй хамтран ажиллаж байна. Хяналт, шинжилгээний тандалт судалгааны мэдээллээр малчдын худаг болон ундны усны эх үүсвэрт сөрөг нөлөө үзүүлээгүй болохыг баталгаажуулсан.

Биологийн төрөл зүйлийн олон янз байдлыг хамгаална

Байгаль орчноо хамгаалах үйлс нь зөвхөн бидний шууд үйл ажиллагаагаар хязгаарлагдахгүй.

2024 онд бид Дархан-Уул аймгийн Шарынгол, Хонгор суманд нийт 215 га газрыг нөхөн сэргээж, бүс тухайн орон нутгийн түншүүдтэй хамтран хууль бус уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдрэн сүйдсэн газрыг нөхөн сэргээлээ.

2024 онд нийт хог хаягдлын 75 хувийг дахин боловсруулж, өнгөрсөн нэг жилийн хугацаанд 17 үндэсний дахин боловсруулах компанитай хамтран ажилласан байна.

Байгаль орчин, хөрст дэлхийгээ хамгаалахад үзүүлж буй бидний манлайлал 2024 оны эцсийн байдлаар байгаль орчны ноцтой осол бүртгэгдээгүй амжилтаар илэрч байгаа юм. Энэ нь бидний тогтмол хяналт, байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг хамгийн бага түвшинд байлгах амлалтын үр дүн юм.



Өмнө

Дараа



ХҮРТЭХ ӨГӨӨЖ

ТОГТВОРТОЙ ҮНЭ ЦЭН БҮТЭЭНЭ

Дэлхийд тэргүүлэх зэсийн
бизнесийг цогцлооно



Оюу толгойн ирээдүй - гүний уурхайн хүдрээс гарган авсан
зэсийн баяжмал

2024 онд уурхайн олборлолт, үйлдвэрлэл чамгүй бэрхшээлтэй тулгарласан ч манай хамт олон хатуужилттай даван туулж, санхүүгийн сахилга батыг үзүүлж чадсан. Энэ жил бид Оюу толгойн түүхэн дэх хамгийн том тээрмийн их засварыг амжилттай гүйцэтгэж, Агааржуулалтын хойд болон урд амууд, мөн гүний уурхайн материал зөөвөрлөх систем зэрэг чухал дэд бүтцүүдийг төлөвлөгөөний дагуу ашиглалтад орууллаа.

Дээрх амжилтууд нь манай байгууллагын хувьд урдаа тавьсан зорилтдоо тууштай төвлөрч анхаарлаа бүрэн хандуулсны шууд үр дүн бөгөөд бидний ирээдүйн тогтвортой өсөлтийн бөх бат суурь болж өгөх юм.

НИЙТ БОРЛУУЛАЛТЫН ОРЛОГО

2,184 сая
ам.доллар

34%



vs 2023

БАЯЖМАЛ ДАХЬ НИЙТ ЗЭС ҮЙЛДВЭРЛЭЛ

('000 тонн)

215

28%



vs 2023

ГҮНИЙ УУРХАЙН ОЛБОРЛОЛТЫГ НЭМЭГДҮҮЛЭХ АЖЛУУД ҮРГЭЛЖИЛЛЭЭ

- ПАНЕЛ 0-ийн 124 ХҮДЭР
ЮУЛҮҮРИЙГ 100 ХУВЬ НЭЭВ
- ГҮНИЙ УУРХАЙГААС ГАЗРЫН ГАДАРГА
РУУ ХҮДЭР ТЭЭВЭРЛЭХ ТУУЗАН
ДАМЖУУРГЫГ АМЖИЛТТАЙ ТУРШИВ
- АГААРЖУУЛАЛТЫН УРД БОЛОН ХОЙД
АМУУДЫГ АШИГЛАЛТАД ОРУУЛАВ

БАЯЖМАЛ ДАХЬ НИЙТ АЛТ ҮЙЛДВЭРЛЭЛ

('000 унц)

206

16%



vs 2023



2024 оны баяжмал дахь зэсийн үйлдвэрлэл өнгөрсөн оноос 28 хувиар өссөн нь бидний дэлхийн дөрөв дэх том зэсийн үйлдвэрлэгч болох зорилгодоо нэгэн алхам ойртсоныг илтгэх чухал үзүүлэлт байлаа.

Үнэ

Зэсийн дундаж үнэ 2024 онд өмнөх оноос 9 хувиар өсөж тонн нь 9,308 ам.долларт хүрсэн боловч 2024 оны эцсээр буурсан төлөвтэй байв.


Алтны дундаж үнэ өнгөрсөн оны мөн үетэй харьцуулбал 25 хувиар өсөж унц нь 2,426 ам.доллар болсон. 2024 оны аравдугаар сарын сүүлээр зах зээлийн унц алтны үнэ 2,778 ам.долларт хүрснээр түүхэн амжилт тогтоов.

Үйлдвэрлэл

Гүний уурхайгаас олборлосон хүдрийн хэмжээ харьцангуй бага байсантай холбоотойгоор 214,989 тонн зэс үйлдвэрлэсэн нь төлөвлөгөөнөөс 9 хувиар бага, 206,352 унц алт үйлдвэрлэсэн нь төлөвлөгөөнөөс 6 хувиар доогуур байсан ч үйлдвэрлэсэн нийт зэсийн баяжмал 993,966 тонн хүрсэн нь өнгөрсөн онтой харьцуулахад 23 хувиар өсжээ. Ил уурхайгаас 106.9 сая тонн чулуулаг зөөвөрлөх төлөвлөгөөтэй байсан ч оны эцэст 99.9 сая тонн болж буурсан нь Дөрөвдүгээр сард уурхайн ачих нэгжид эвдрэл гарсантай холбоотой. Цаг агаарын таагүй нөхцөл байдал мөн ил уурхайн үйл ажиллагаанд нөлөөлж байсан хэдий ч манай хамт олон аюулгүй ажиллагаа, үйлдвэрлэлд үндсэн анхаарлаа хандуулан

ажиллаж ноцтой эрсдэлээс ангид байж чадсан. Гүний уурхайгаас зөөвөрлөсөн чулуулгийн хэмжээ өдрийн 33,000 тоннд хүрч шинэ дээд амжилт тогтоосон ч жилийн эцэст нийт 6.3 сая тонн чулуулаг зөөвөрлөж, 7.4 сая тонныг зөөвөрлөх төлөвлөгөөндөө хараахан хүрээгүй. Хүдэр боловсруулалт болон ашиглалтын түвшин жилийн зорилтын дагуу байв. Оюу толгойн түүхэн дэх хамгийн том их засварын ажлыг тээрэм дээр хуваарийн дагуу амжилттай гүйцэтгэсэн бөгөөд энэ ажилд 1400 гаруй хүн гар бие оролцов. Хаягдлын далангийн Үүр 2-ыг тавдугаар сард амжилттай ашиглалтад оруулсан нь уурхайн боловсруулах дэд бүтцийг бэхжүүлэх чухал алхам байлаа.

БАЯЖМАЛ
ДАХЬ ЗЭС
ҮЙЛДВЭРЛЭЛ
(‘000 тонн)



Борлуулалтын орлого

Оюу толгойн зэс, алтны үйлдвэрлэл өссөн, мөн дэлхийн зах зээл дээрх таваарын үнэ сайжирсантай холбоотойгоор 2024 оны борлуулалтын орлого өнгөрсөн оноос 34 хувиар нэмэгдсэн.


Энэ онд “Оюу толгой” компани 198 мянган тонн зэс (2023 онд 166 мянган тонн), 191 мянган унц алт (2023 онд 175 мянган унц), 1,244 мянган унц мөнгө (2023 онд 1,008 мянган унц) тус тус агуулсан 963 мянган тонн баяжмал (2023 онд 823 мянган тонн) борлуулж, 2.2 тэрбум ам.долларын (2023 онд 1.6 тэрбум ам.доллар) орлого олсон.

Сая ам.доллар	2024	2023	2022	2021	2020	2019	2018
Борлуулалтын орлого	2,184	1,625	1,424	1,971	1,078	1,166	1,180
Үндсэн үйл ажиллагааны, татвар, хүү, элэгдлийн өмнөх ашиг *	710	574	436	1,205	379	350	367
Үндсэн үйл ажиллагааны, татвар, хүү, элэгдлийн өмнөх ашгийн хувь*	33%	35%	31%	61%	35%	30%	29%
Урсгал капиталын зардал	176	150	152	89	59	134	91
Гүний уурхайн капитал зардал	495	567	492	621	914	1,194	1,234
Гүний уурхайн урсгал капиталын зардал	645	531	433	238	97	-	-
Улсад төлсөн татвар, шимтгэл, бусад төлбөр**	422	297	207	593	200	209	200

*Хүү, татвар, элэгдэл, хорогдлын өмнөх ашиг/алдагдал нь орлогын тайланд тусгагдсан Хүү, татвар, элэгдэл, хорогдлын өмнөх ашиг/алдагдал харуулах ба энэ дүн нь үнэ цэнийн бууралтын ямар нэгэн нөлөөг агуулаагүй болно.

** Дотоод худалдан авалтад төлсөн НӨАТ ороогүй дүн. “Оюу толгой” ХХК НӨАТ-ын хасалт хийдэггүй.

Баяжмалын борлуулалт (‘000 тонн, хуурай)




Урсгал капиталын зардал


Урсгал капиталын зардал 2023 онд 150 сая ам.доллар байсан бол энэ онд 176 сая ам.доллар болж 26 сая ам.доллараар өсөв. Энэхүү өсөлт нь үйл ажиллагааны найдвартай байдлыг хангахад шаардлагатай тоног төхөөрөмжүүдийг худалдан авсантай холбоотой.

Тоног төхөөрөмжийн шинэчлэл, засварын зардал өнгөрсөн оноос буурсан бөгөөд барилгын ажил багассантай холбоотойгоор хаягдал хадгалах байгууламжийн зардал мөн буурсан. Хойшлуулсан хөрс хуулалтын зардал 2023 оны дүнгээс 14 сая ам.доллараар өндөр байгаа нь хөрс хуулалтын хэмжээ нэмэгдсэнийг харуулж байна.


ГҮНИЙ УУРХАЙН ТӨСЛИЙН 2024 ОНЫ ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ



Гүний уурхайгаас газрын гадарга руу хүдэр тээвэрлэх туузан дамжуургын тестийг энэ оны 10-дугаар сард амжилттай гүйцэтгэснээр 1300 метрийн гүнээс хүдрийн материал тээвэрлэх боломжтой болов.



Баяжуулах үйлдвэрийн өргөтгөлийн барилгын ажил төлөвлөгөөний дагуу үргэлжилж байгаа бөгөөд 2025 онд дуусна.



Анхдагч бутлуур 2-ын барилгын ажил амжилттай үргэлжилж, 2025 онд багтаан дуусгах төлөвлөгөөтэй байна.




Татвар, шимтгэл, бусад төлбөр

2024 онд Монгол Улсын Засгийн газарт татвар, шимтгэл, бусад төлбөрт (дотоод худалдан авалтад төлсөн НӨАТ-ыг оруулахгүйгээр) 422 сая ам.доллар төлсөн нь 2023 оныхоос (297 сая ам.доллар) 125 сая ам.доллараар илүү байна. Энэхүү өсөлт нь 2019 болон 2020 оны татварын аудитын (одоогийн байдлаар арбитрын шүүхээр хэлэлцэж байгаа) хүрээнд 2024 оны 1-р сард хийсэн төлбөр, таваарын үнэ болон баяжмалын тээвэрлэлт өссөнтэй холбоотойгоор АМНАТ өссөн зэрэг нөлөөнөөс голчлон үүдэлтэй.

“Оюу толгой” компани 2024 онд Гүний уурхайн бүтээн байгуулалтыг санхүүжүүлэх, төслийн санхүүжилтийн зээлийн хүүг төлөх зорилгоор 871 сая ам.долларын (2023 онд 1,061 сая ам.доллар) санхүүжилт татсан. Санхүүжилтийн 70 сая ам.долларыг Эргэлтийн хөрөнгийн зээл, 801 сая ам.долларыг шинэ Спонсорын давуу эрхтэй зээл хэлбэрээр татсан (2023 онд Спонсорын давуу эрхтэй зээл 850 сая ам.доллар, баяжмал борлуулалтын урьдчилгаа төлбөр 211 сая ам.доллар тус тус байв). Оны эцэст нийт нийт зээл болон хуримтлагдсан хүүний хэмжээ 18.71 тэрбум ам.доллар байлаа.



Гүний уурхайн төсөлтэй холбоотой хийгдсэн нийт үүрэг 6.85 тэрбум ам.долларт хүрсэн. Үүнээс 5.21 тэрбум ам.долларын гэрээ хэлцлийг дотоодын ханган нийлүүлэгчидтэй байгуулж 2016 онд анх тавьсан 1.4 тэрбум ам.доллар, 2018 онд шинэчилсэн 2 тэрбум ам.долларын зорилтоо давуулаад байгаа нь “Оюу толгой” компанийн дотоодын бизнес эрхлэгчдийг дэмжих зорилтын тод илрэл юм.



Гүний уурхайн төслийн капитал зардал

2024 онд гүний уурхайн төслийн капитал зардал 495 сая ам.доллар байсан нь 2023 онтой (567 сая ам.доллар) харьцуулахад 72 сая ам.доллараар буурсан нь төслийн цар хүрээний томоохон ажлууд амжилттай хэрэгжиж дууссантай холбоотой (үүнд капитал цар хүрээний гүний уурхайн бүтээн байгуулалт орно).



Гүний уурхайн урсгал капитал зардал

Гүний уурхайн урсгал капитал зардал 2024 онд 645 сая ам.доллар байсан нь 2023 оноос (531 сая ам.доллар) даруй 114 сая ам.доллараар өссөн дүн юм. Энэ өсөлт нь Панел 1, 2-ын барилгын болон бүтээн байгуулалтын ажил мөн гүний уурхайн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэхэд шаардлагатай тоног төхөөрөмж, байгууламжийн зардалтай холбоотой юм.

Худалдан авах ажиллагаа, гэрээний багцуудаар дамжуулан дотоодын ханган нийлүүлэгчдэд зарцуулсан дүн нь төслийн худалдан авах ажиллагааны нийт дүнгийн 78 хувийг эзэлж буй нь “Оюу толгой” компанийн дотоодын бизнес эрхлэгчдийг дэмжих зорилтын тод илрэл юм.



Төлөөлөн удирдах зөвлөл



Галсангийн Батсүх
Элчин сайд, Төлөөлөн удирдах зөвлөлийн Дарга
(2024 оны 10 сар хүртэл)



Шон Хинтон
Төлөөлөн удирдах зөвлөлийн Дарга
(2024 оны 10 сараас)

Дэйрдрэ Лингенфэлдер
Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн

Энхбаатарын Баясгалан
Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн

Крейг Стэгман
Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн

Морита Сүтэджа
Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн
(2024 оноос)

Элиас Скафидас
Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн
(2024 оны 4 сар хүртэл)

Сүхбаатарын Мөнхсүх
Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн

Энхтайваны Мэндтүвшин
Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн
(2024 оны 11 сараас)

Стив Тибоу
Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн

Жамбалдоржийн Тана
Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн
(2024 оны 10 сар хүртэл)

Намсрайн Цэрэнбат
Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн

ТУЗ ба Хувьцаа эзэмшигчдийн хурал

Хувьцаа эзэмшигчдийн хурал


- Хувьцаа эзэмшигчдийн 22-р хурал - 2024 оны 4-р сарын 26 (жил тутмын ерөнхий хурал)

Төлөөлөн удирдах зөвлөлийн ээлжит хурал

- 56-р хурал - 2024 оны 3-р сарын 14-нд хуралдаж, 3-р сарын 18, 25, 26, 5-р сарын 2-нд үргэлжилсэн
- 57-р хурал - 2024 оны 6-р сарын 6
- 58-р хурал - 2024 оны 9-р сарын 12
- 59-р хурал - 2024 оны 11-р сарын 29-нд хуралдаж, 12-р сарын 16, 18, 27-нд үргэлжилсэн

Төлөөлөн удирдах зөвлөлийн ээлжит бус хурал

- Ээлжит бус 48-р хурал – 2024 оны 9-р сарын 12-нд хуралдаж, 11-р сарын 8, 11-нд үргэлжилсэн



Аудит, санхүүгийн хорооны хурал

- Аудит, санхүүгийн хорооны 58-р хурал - 2024 оны 3-р сарын 13
- Аудит, санхүүгийн хорооны 59-р хурал - 2024 оны 6-р сарын 5
- Аудит, санхүүгийн хорооны 60-р хурал - 2024 оны 9-р сарын 11
- Аудит, санхүүгийн хорооны 61-р хурал хуралдаж, 11-р сарын 29-нд үргэлжилсэн - 2024 оны 11-р сарын 27-нд

Үйл ажиллагааны хорооны хурал

- Үйл ажиллагааны хорооны 54-р хурал - 2024 оны 3-р сарын 13
- Үйл ажиллагааны хорооны 55-р хурал - 2024 оны 6-р сарын 5
- Үйл ажиллагааны хорооны 56-р хурал - 2024 оны 9-р сарын 11
- Үйл ажиллагааны хорооны 57-р хурал - 2024 оны 11-р сарын 28

Хүний нөөц, сургалтын хорооны хурал

- Хүний нөөц, сургалтын хорооны 54-р хурал - 2024 оны 3-р сарын 13
- Хүний нөөц, сургалтын хорооны 55-р хурал - 2024 оны 6-р сарын 5
- Хүний нөөц, сургалтын хорооны 56-р хурал - 2024 оны 9-р сарын 11
- Хүний нөөц, сургалтын хорооны 57-р хурал - 2024 оны 11-р сарын 28

Хамтын ажиллагааны хорооны хурал

- Хамтын ажиллагааны хорооны 27-р хурал - 2024 оны 3-р сарын 13
- Хамтын ажиллагааны хорооны 28-р хурал - 2024 оны 6-р сарын 5
- Хамтын ажиллагааны хорооны 29-р хурал - 2024 оны 9-р сарын 11
- Хамтын ажиллагааны хорооны 30-р хурал - 2024 оны 11-р сарын 28



